



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2018 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 04

Арвайхээр

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2018 оны 01/3753 дугаар албан бичиг бүхий “Зөрчил арилгуулах тухай” зөвлөмжийг хэрэгжүүлэх, гарсан зөрчил дутагдлыг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зорилгоор Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Сумдын Засаг дарга нарт:

1.1. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрлэх эрх хэмжээний (тухайлбал, төлбөр хураамж тогтоох, дүрэм журам батлах, газар зохион байгуулалтын болон бусад төлөвлөгөө батлах, өмч хөрөнгө, захиран зарцуулах гэх мэт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах) асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр шийдвэрлэдэг, өөрчлөлт оруулдаг зэрэг зөрчил нийтлэг гарч байгааг таслан зогсоох, өмнөх шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, холбогдох ажилтныг сургаж, чадавхижуулах

1.2. Сумын хэмжээнд мөрдөж буй аливаа төлбөр, хураамж тогтоосон шийдвэрийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх

1.3. Үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм, журмыг нэг бүрчлэн эргэн нягталж, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг журамласан, захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлвэл зохих дүрэм, журмыг хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсний үндсэн дээр дагаж мөрдөх

1.4. Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлж болох үйл ажиллагаанд элдэв зөвшөөрөл, гэрээ, гэрчилгээ, төлбөр хураамж гэх мэт баримт бичиг шаардах, олгох явдлыг таслан зогсоох, хууль тогтоомжоор хязгаарлаагүй тохиолдолд үйл ажиллагаа саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх

1.5. Сумдын Засаг дарга нар хууль, журамд заасан зөвхөн өөрт олгогдсон бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргах

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.19 дэх хэсэгт зааснаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг тогтоох” эрхийг зөвхөн Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгосон тул сумдын Засаг дарга нар нөөц хөрөнгийн зориулалтыг өөрчилж журам баталсан нөхцөлд журмыг

011200007

хүчингүй болгож, цаашид Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах

2. Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт:

2.1. Төрийн албаны тухай хууль, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус зөрчиж түр орлон гүйцэтгэгчээр томилсон шийдвэрийг хүчингүй болгон, удирдах албан тушаалд томилогдох ажилтны сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл, Боловсрол, соёл, урлагийн газарт ирүүлэн сонгон шалгаруулалтыг зарлуулах

2.2. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалтад ороогүй, тэнцээгүй, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэгдээгүй, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дүгнэлтгүйгээр холбогдох хууль, журам зөрчиж түр болон бүр томилсон иргэнийг чөлөөлж, сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлд ирүүлэн, мэргэшлийн шалгалтыг зарлуулах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд сул орон тоонд иргэнийг томилохгүй байх

2.3. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр томилох, томилсны дараа хянуулах зөрчлийг таслан зогсоох


2.4. Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ) гаргаж хэвшүүлэх, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх, түүнд тавих хяналтыг сайжруулах

2.5. Эрх бүхий албан тушаалтнууд нь Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон албан тушаалтны томилогдохын өмнөх хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах, томилогдсоны дараа 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах

2.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр ханган, хяналт тавьж ажиллах

3. Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг сум, байгууллагынхаа түвшинд зохион байгуулан, биелэлтийг жил бүр дүгнэж, тайлагнахыг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД